

БАТЛАВ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН

ЗАСАГ ДАРГА  А.ЭРДЭНЭСАЙХАН

БАТЛАВ
“ТРЕНД ОВНЕР КАПИТАЛ” ХХК-НЫ

ЗАХИРАЛ  Т.БААСАНЦОГТ

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЦАГААНДЭЛГЭР СУМЫН
“ЗУРАГ ТӨСӨВ” - ИЙН АЖЛЫН ГЭРЭЭ
ДУГААР № ДУГАЦДСЗДТГ/202304019

2023 оны 06 дугаар сарын 26

Хараат

Нэг талаас (цаашид “Захиалагч” гэх) Засаг дарга А.Эрдэнэсайхан, нөгөө талаас “ТРЕНДОВНЕР КАПИТАЛ” ХХК-ны захирал Т.Баасанцогт (цаашид “Гүйцэтгэгч”гэх) нар дараах зүйлсийг харилцан тохиролцож 2023 оны 06 дугаар сарын 26 –ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, ажил гүйцэтгэхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын “Зураг төсөв”-ийн ажлыг ДУГАЦДСЗДТГ/202304019 дугаартай (цаашид “гэрээний үүрэг” гэх) 20,000.000 (Хорин сая) төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь “Зураг төсөв” -ийн ажлын 20,000,000 (Хорин сая) төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлнэ.
4. Гүйцэтгэгч нь тус сумын “Зураг төсөв”- ийн ажлыг заагдсан нөхцлийн дагуу 2023 оны 06 дугаар сарын 25 - ны өдөр эхлүүлж 2023 оны 07 дугаар сарын 20 -ны өдрийн дотор чанартай хийж гүйцэтгэнэ.
5. Санхүүжилтийг ажлын гүйцэтгэл дууссаны дараа ажлын 5 хоногийн дотор 100% олгоно.
6. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 6.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 6.2 Бусад шаардлагатай баримт бичиг;
- 6.3 Гүйцэтгэгчийн ирүүлсэн санал;
- 6.4 Гэрээний тусгай нөхцөл;
- 6.5 Гэрээний ерөнхий нөхцөл;
- 6.6 Ажлын зураг, техникийн тодорхойлолт
- 6.7 Гүйцэтгэгчийн ирүүлсэн үнэ бүхий үйл ажиллагааны хуваарь
- 6.8 Санхүүжилтийн хуваарь

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

7. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
8. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.
9. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хүлээнэ.
10. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.
11. Зураг төслийн ажлыг барилгын зураг төсөл зохиоход мөрдөж буй норм, дүрэм бусад холбогдох техникийн баримт бичгийн дагуу чанартай боловсруулан гэрээт хугацаанд хүлээлгэн өгөх ба хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үнийн дүнгийн 3 хувиар алданги ногдуулна. Гэхдээ алданги хүлээснээр үүргийн гүйцэтгэлээс чөлөөлөгдөхгүй.


12. Захиалагч болон гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас үл хамааран ажил гүйцэтгэх хугацаанд саатал гарсан тохиолдолд хамтран тохиролцож, ажлын графикт зохицуулалт хийсний үндсэн дээр ажил дуусгах хугацаанд өөрчлөлт оруулж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЦАГААНДЭЛГЭР СУМЫН
ЗДТГ-ЫН ДАРГА
..... МӨНХ-ОРГИЛ

ХАЯГ: Дундговь аймгийн Цагаандэлгэр
Утас: 95971666



ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“ТРЕНДОВНЕР КАПИТАЛ” ХХК-ЫГ
ТӨЛӨӨЛЖ

..... Л.ЖАРГАЛСАЙХАН

ХАЯГ: УЛААНБААТАР ХОТ

Харилцах банк: ХХБАНК

Регистрийн дугаар: 423055755

Утас: 99016241, 88104316